



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/143

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIII.1.3.9 дугаартай Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д төсөл арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/60 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д зарцуулах 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданям)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100310

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 07/113 дүгээр захирамжийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН ХУУЛИЙН XIII.1.3.9 ДУГААРТАЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ (ӨВӨРХАНГАЙ) ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Есөнзүйл, Сант, Төгрөг сумдын Ерөнхий боловсролын сургууль, Уянга сумын 1 дүгээр сургууль, Хархорин сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль шалгалтын материал засагч программ, тоног төхөөрөмж	35000,0
2	Бат-Өлзий, Уянга, Богд 1,2, Хужирт 1,2,3,4, Хархорин 1,2,3,4,5, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Төгрөг, Сант, Хайрхандулаан, Гучин-Ус, Тарагт, Өлзийт, Бүрд сумдын цэцэрлэгүүдэд зөөврийн компьютер, техник хэрэгслээр хангах	50000,0
3	Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Нарийнтээл, Тарагт сумдын Ерөнхий боловсролын сургуулиудад химийн кабинет, Уянга сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Мэргэд сургууль, Баруунбаян-Улаан, Төгрөг, Баянгол сумдын сургуулиудад Физикийн кабинетыг тус тус байгуулах	100000,0
4	Арвайхээр, Хархорин сумдын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Арвайхээр сумын Тэмүүлэл-Эрдэм, Тарагт сумын Ерөнхий боловсролын сургууль, Хархорин Номын хүрдэн сургуулиудад цэвэр усны шүүлтүүр тавих, Нарийнтээл сумын Баянтээг багийн бага сургууль, Төгрөг, Гучин-Ус, Богд, Уянга, Нарийнтээл, Бат-Өлзий, Сант, Есөнзүйл, Хужирт, Бүрд, Баянгол, Баруунбаян-Улаан, Уянга, Уянга сумын Жаргалант, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Өлзийт, Баян-Өндөр сумдын Ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд шүүлтүүртэй ундны усны тоног төхөөрөмж суурилуулах	66500,0
5	Хархорин, Арвайхээр сумдын 1-р сургууль, Бүрд, Сант сумдын Ерөнхий боловсролын сургууль, Бат-Өлзий сумын 1-р цэцэрлэг, Хужирт сумын 3 дугаар цэцэрлэг, Бүрд сумын цэцэрлэгт орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камераар хангах	45000,0
6	Хужирт сумын 3,4, Уянга сумын 1 дүгээр цэцэрлэг, Арвайхээр сумын бүх цэцэрлэгүүдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэл	60000,0
7	Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэг, Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тусгай бүлэг, Хархорин сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тусгай бүлэгт шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүн	20000,0
8	Уянга сумын Жаргалант, Нарийнтээл, Бат-Өлзий, Хужирт, Есөнзүйл сумдын Ерөнхий боловсролын сургууль, Хужирт сумын 4-р цэцэрлэгийг шаардлагатай гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах	60000,0
9	Уянга, Хархорин сумдын 1, 2 дугаар сургууль, Хархорин сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль, Арвайхээр, Баруунбаян-Улаан, Бат-Өлзий, Баян-Өндөр, Баянгол, Баянтээг, Богд, Бүрд, Гучин-Ус, Есөнзүйл, Уянга сумын Жаргалант баг, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Сант, Тарагт, Тарагт сумын Туяа баг, Төгрөг, Өлзийт, Хайрхандулаан, Хужирт сумын сургууль, Мэргэд, Тэмүүлэл-Эрдэм, Номын хүрдэн сургуулиуд, Хайрхандулаан, Тарагт, Бат-Өлзий сумдын цэцэрлэгүүдийг хөгжмийн зэмсэгээр хангах	25000,0
10	Хархорин сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль, Уянга, Хархорин сумдын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Өлзийт, Бүрд сумдын Ерөнхий боловсролын сургуулиудад биеийн тамирын хэрэглэгдэхүүн	38500,0
	НИЙТ ДҮН	500000.0